

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

"ХХҮШ.8. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2013 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг Сангийн сайд Ч.Улаан хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. Үүнд:

1. Үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдалд дүн шинжилгээ хийж, цаашид худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг чанд мөрдөн ажиллаж, 2014 оны худалдан авах ажиллагааны улирлын тайланг тогтоосон хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх;

2. Монгол Улсын төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагааны бүх тендерийг 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор зарлах, 6 дугаар сарын 15-ны байдлаар дүгнэж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн байх." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР